

M-CHAT-R

Та хүүхдийнхээ тухай дараах асуултуудад бүрэн хариулт өгнө уу. Та асуултын хариултыг сонгохдоо хүүхдийнхээ ихэвчлэн гаргадаг зан, үйлдлийн дагуу бөглөнө үү.

1. Та өрөөний нөгөө талд байгаа зүйл рүү заахад, хүүхэд таны заасан зүйл рүү харж байна уу? (Жишээлбэл: Та ямар нэгэн тоглоомыг заахад хүүхэд тоглоом руу хардаг уу?)
Тийм Үгүй
2. Та хүүхдээ дүлий байх вий хэмээн бодож байсан тохиолдол бий юу?
Тийм Үгүй
3. Таны хүүхэд төсөөлөн тоглодог уу? (Жишээлбэл: хоосон аяганаас цай ууж байгаа мэт дүр үзүүлэх, утсаар ярих, хүүхэлдэйгээ хооллох гэх мэт)
Тийм Үгүй
4. Таны хүүхэд аливаа зүйл рүү авирах дуртай юу (Жишээлбэл: гэрийн тавилга, шат, тоглоомын талбайн тоглоомууд)?
Тийм Үгүй
5. Таны хүүхэд нүднийхээ ойролцоо хуруугаараа хэвийн бус үйлдэл үзүүлдэг үү (жишээлбэл: нүднийхээ ойролцоо хуруугаа займчуулах)?
Тийм Үгүй
6. Таны хүүхэд авахыг хүссэн зүйлээ илэрхийлэхдээ хуруугаараа заадаг уу? (Жишээлбэл: өөрийх нь гар хүрэхээргүй газар байрлах тоглоом, хоол гэх мэт)
Тийм Үгүй
7. Таны хүүхэд сонирхсон зүйлсээ илэрхийлэхдээ хуруугаараа зааж, тухайн зүйл рүү таны анхаарлыг татдаг уу (Жишээлбэл: замаар явж байгаа том вагон эсвэл нисч байгаа онгоц зэргийг заах)?
Тийм Үгүй
8. Таны хүүхэд бусад хүүхдүүдэд анхаарлаа хандуулах, тэднийг сонирхон хардаг уу (Жишээлбэл: таны хүүхэд бусад хүүхдүүдийг анхааралтай харах, тэдэн рүү харж инээх, тэдэнтэй тоглох гэж оролдох)?
Тийм Үгүй
9. Таны хүүхэд танд үзүүлэх, харуулахаар аливаа зүйлсийг авчирж өгдөг үү (Жишээлбэл: чихмэл тоглоом, цэцэг, тоглоомон машин гэх зэрэг)?
Тийм Үгүй
10. Та хүүхдээ нэрээр нь дуудахад танд хариу илэрхийлдэг үү (Жишээлбэл: тань руу харах, таньтай ярих, эсвэл таныг дуудах үед хийж байсан үйлдлээ болих)?
Тийм Үгүй
11. Хүүхэд рүүгээ инээмсэглэж харахад танруу хариу инээмсэглэдэг үү?
Тийм Үгүй
12. Таны хүүхэд өдөр тутамд гардаг дуу чимээнд түүртдэг үү (Жишээлбэл: тоос сорогч, чанга хөгжим дуугарахад уйлах, орилох)?
Тийм Үгүй
13. Таны хүүхэд алхаж чадах уу?
Тийм Үгүй
14. Та хүүхэдтэйгээ тоглох, ярих, хүүхдээ хувцаслах үед таны нүд рүү хардаг уу?
Тийм Үгүй

15. Таны хийсэн үйлдлийг хүүхэд дуурайдаг уу (Жишээлбэл: Баяртай гэж гараараа даллах, алга даших, инээдтэй дуу авиа гаргах гэх мэт)
- Тийм Үгүй
16. Таныг өөр зүйлд анхаарлаа хандуулах үед хүүхэд таны харж байгаа зүйлийг харахаар өрөөг тойруулан хардаг уу?
- Тийм Үгүй
17. Хүүхэд өөрийхөө хийж байгаа зүйлийг таньд харуулахыг оролддог уу (Жишээлбэл: Намайг хардаа, энийг хараач гэх мэтээр)?
- Тийм Үгүй
18. Таны хүүхэд таны зааврыг биелүүлдэг үү (Жишээлбэл: Та гараараа үзүүлэлгүйгээр номоо сандал дээр тавь эсвэл даавуугаа надаа өг гэх зэрэг энгийн зааврууд өгөхөд биелүүлэх)?
- Тийм Үгүй
19. Ямар нэг шинэ зүйл тохиолдоход, хүүхэд таныг хэрхэн мэдэрч байгааг мэдэхийн тулд таны нүүр рүү хардаг уу (Жишээлбэл: Ямар нэг танил бус дуу чимээ, эсвэл шинэ тоглоом авахыг хүсэхдээ таны нүүр рүү харах)?
- Тийм Үгүй
20. Таны хүүхэд хөдөлгөөнт байдлаар тоглох дуртай юу? (Жишээлбэл: Таны өвдгөн дээр үсрэх, савлах)
- Тийм Үгүй